



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2022.11.14 № 50

Төмөрлөгийн үйлдвэрийг дэмжих талаар
Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга
хэмжээний тухай болон
Хөгжлийн банкны зээлийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т тус тус заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд Төмөрлөгийн үйлдвэрийг дэмжих талаар Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай болон Хөгжлийн банкны зээлийн талаар дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Хөгжлийн банктай холбогдуулан гаргасан Засгийн газрын тогтоолуудад дурдагдсан аж ахуйн нэгжүүд болон нийт төслийн хэдэн хувьд нь тус банк санхүүжилт олгосон талаар /2013-2016 он/;
2. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн "Төмөрлөгийн үйлдвэрийг дэмжих тухай" 256 дугаар тогтоолын биелэлтийн талаар;
3. Уг тогтоол нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2012 оны 12 дугаар сарын 03-ний өдөр гаргасан "Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай" 28/20 тоот зөвлөмжийг хангаж чадсан эсэх;
4. Уг тогтоолд заасан "Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэр болон Барилгын арматурын үйлдвэрийг барьж байгуулахад шаардлагатай байгаа 50.0 (тавин) сая хүртэлх ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилтийг хавсралт ёсоор баталсугай." гэсэн нь Хөгжлийн банк энэ дөрвөн зээлийг заавал олгох ёстой эсэх талаар;
5. Хөгжлийн банк дээрх тогтоолд дурдагдсан 4 аж ахуйн нэгжээс хэдэн аж ахуйн нэгжид хэдэн төгрөгийн зээл /ам.доллар/ олгосон, хэдэн аж ахуйн нэгжид зээл олгоогүй /хэдэн ам.доллар/ талаар;
6. Хөгжлийн банкны зээл олгосон аж ахуйн нэгж болон хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүд нь тус банкны хуульд заасан шаардлагыг хангаж байсан эсэх /барьцаа хөрөнгө, өөрөө босгох хөрөнгөө хэрхэн бүрдүүлсэн талаар/;

7. Зээл олгосон дээрх 2 аж ахуйн нэгжийн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл болон зээлийг төлүүлэх талаар Хөгжлийн банкнаас авсан арга хэмжээний талаар;
8. 2017 онд "Бэрэн групп" ХХК-д орон сууцны хороолол барих Хөгжлийн банкны 2 дахь зээлийг /11.7 сая ам.доллар/ яагаад нэмж олгосон талаар;
9. Хөгжлийн банк нэмж зээл олгосон нь 2014 онд тус компанид Төмөрлөгийн үйлдвэр барих зориулалтаар өмнөх олгосон зээл хэвийн явж байсан нотолгоо болох эсэх талаар;
10. Хөгжлийн банк 2018 онд "Бэрэн групп" ХХК-д 3 дахь зээл болох Төмөрлөгийн үйлдвэрийн эргэлтийн зээл /4.5 сая ам.доллар/ олгох шийдвэр гаргахад тус үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байсан эсэх;
11. "Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 81 дүгээр тогтоолын хэрэгжилтийн өнөөгийн байдал, үр дүнгийн талаар;
12. "Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай" Засгийн газрын 2017 оны 42 дугаар тогтоолын хэрэгжилтийн өнөөгийн байдал, үр дүнгийн талаар.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, цаашид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Н.АЛТАНХУЯГ

2022000171